

## ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулийн Хүн Амын Сургалт, Судалгааны Төвтэй хамтран Хүн Амын Хөгжил, Нийгмийн Хамгааллын Яамны санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 22 дахь дугаарыг бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн **“Судалгаа”** хэсэгт Төгрөгийн худалдан авах чадвар ба өрхийн мөнгөн орлого, ядуурлын шугамын бодит өсөлт, Монголын уул уурхайн хөгжил болон хүн амын орлогод гарч буй өөрчлөлтүүд, Уул уурхайн эдийн засаг, түүний хүмүүн капиталд үзүүлэх нөлөөлөл, Улаанбаатар хотын залуучуудын гэр бүл төлөвлөлт, Хэрэглэгчийн сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээнд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа зэрэг судалгаа, шинжилгээний ажлуудаас гарсан үр дүн, санал зөвлөмжийг танилцуулж байна.

**“Үзэл бодол”** хэсгээр цахим сургалтыг хөгжүүлж буй туршлага: АНУ, БНСУ болон Монгол Улсын зарим жишээн дээр, мөн Монголын орон нутгийн засаглалд эмэгтэйчүүдийн оролцоо ямар байгаа талаар эрдэмтдийн өөрсдийн судалгааны ажил дээр тулгуурласан байр суурийг илэрхийлсэн болно.

**“Сургалт”** хэсгээс “Microsoft компаний хэрэглэгчдэд зориулан боловсруулсан бизнес шинжилгээний технологийн шийдэл”-ийн талаар шинэ мэдлэг олж, оюуны цар хүрээгээ тэлээрэй.

Сэтгүүлийнхээ **English** хэсэгт Монголын нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаагаар төрөлтийн түвшин яагаад өндөр гарсан бэ? гэдэгт гүнзгийрүүлсэн шинжилгээ хийж хариулт өгсөн үр дүнг нийтэллээ.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд, хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, эрдэм шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон уг сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Хүн Амын Хөгжил, Нийгмийн Хамгааллын Яаманд сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

**РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ**